

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гэр бүлийн хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Гэр бүлийн харилцааны зарчим

3.1.Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ.

3.2.Иргэнийг гэрлэхэд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

3.3.Монгол Улсад эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна.

3.4.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, гэр бүлийн гишүүний өмнө үүрэг, хариуцлага хүлээнэ.

3.5.Эцэг, эх хүүхдийг биеийн болон оюун санааны хувьд эрүүл өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд түүний эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаална.

3.6.Эцэг, эх хүүхэддээ гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг өвлүүлж, оюун санааны дархлааг бэхжүүлнэ.

3.7.Гэр бүл аюулгүй, амар тайван, хүчирхийллээс ангид байна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.8.Төрөөс гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжинэ.

3.9.Төр хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, эсхүл бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хөёрын(Үндсэн хуульд) хүний чөлөөтэй, сайн дурын харилцаанд үндэслэн гэр бүл болох зорилгоор эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

4.1.2.“гэрлэгчид” гэж гэр бүлийн харилцаанд тэгш эрх эдэлж, үүрэг хүлээхээр гэрлэлтээ иргэний улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхөр, эхнэрийг;

4.1.3.“гэр бүл” гэж гэрлэлт, төрөлт, үрчлэлтийн үр дүнд эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдээс бүрдсэн нийгмийн анхдагч нэгжийг;

4.1.4.“гэр бүлийн гишүүн”-д дараах хүмүүс хамаарна:

4.1.4.а.гэрлэгчид;

4.1.4.б.гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч нэг гэрт хамтран амьдарч байгаа эрэгтэй, эмэгтэй;

4.1.4.в.гэрлэгчдийн эсхүл хамтран амьдрагчдын хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;

4.1.4.д.гэрлэгчдийн эсхүл хамтран амьдрагчдын хамт амьдарч байгаа төрөл, садангийн хүнийг;

4.1.5.“төрлийн хүн” гэж хүний өөрийн болон түүний эхнэр эсхүл нөхрийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

4.1.6.“садангийн хүн” гэж хүний өөрийн болон түүний эхнэр эсхүл нөхрийн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

4.1.7.“овог” гэж гэр бүл, түүний ураг төрлийнхөн үе уламжлан хэрэглэх нэрийг;

4.1.8.“үрчлэлт” гэж шүүхийн шийдвэрийн дагуу үрчлэн авсан эцэг, эх болон үрчлүүлсэн хүүхдийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн адил эрх, үүрэг үүсгэхээр иргэний улсын бүртгэлд бүртгүүлснийг;

4.1.9.“асран хамгаалах” гэж эцэг, эхийн асран хамгаалалтгүй болсон 14 насанд хүрээгүй хүүхдийг, эсхүл сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.10.“харгалзан дэмжих” гэж эцэг, эхийн харгалзан дэмжлэггүй болсон 14 ба түүнээс дээш насны хүүхдийн, эсхүл эрүүл мэндийн байдлын болон өндөр настай болсны улмаас, эсхүл иргэний эрх зүйн чадамжийг нь шүүхээс хязгаарласны улмаас эрх үүргээ бие даан хэрэгжүүлэх боломжгүй болсон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.11.“хүйсийн өөрчлөлт” гэж мэс заслын аргаар нөхөн үржихүйн үйл ажиллагааг зогсоож, эсхүл өөрчилснийг эрүүл мэндийн байгууллага гэрчилж, иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхийг;

4.1.12.“нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болох” гэж Донорын тухай хуулийн 3.1.15, 3.1.16, 3.1.18-д тус тус заасныг;

4.1.13.“сонирхогч тал” гэж 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө, эсхүл түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, эрх ашиг нь хөндөгдсөн эсхүл зөрчигдсөн гуравдагч этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭРЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМ, ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛОХ

5 дугаар зүйл.Гэрлэх нөхцөл

5.1.Энэ хуулийн 8.1-д заасантай харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хоёр, эсхүл Монгол Улсын иргэн нь тухайн улсын гэрлэх насанд хүрсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй сайн дурын үндсэн дээр Монгол Улсад гэрлэж болно.

5.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно.

5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно.

6 дугаар зүйл.Гэрлэх журам

6.1.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу эрх бүхий төрийн байгууллагад биеэр хүрэлцэн ирж, гэрчийн этгээдийг байлцуулан бүртгүүлнэ.

6.2.Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн хооронд эрх, үүрэг үүснэ.

7 дугаар зүйл.Гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээ, үр дагавар

7.1.Энэ хуулийн 5.2-т заасны дагуу гэрлэхийг хүсэгчид сэтгэцийн эрүүл мэндийн, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол,

бэлгийн замын халдвар, сүрьеэ өвчин, удамшлын эмгэгтэй эсэхийг тогтоох эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаж болно.

7.2.Энэ зүйлийн 7.1-д заасан өвчтэй, халдвартай нь тогтоогдсон тохиолдолд эмч, эмнэлгийн ажилтан тухайн өвчин, түүний үр дагаврын талаар тухайн этгээдэд тайлбар, зөвлөгөө өгч, шинжилгээний хариуг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хадгална.

7.3.Энэ зүйлийн 7.1-д заасан өвчтэй, халдвартай нь тогтоогдсон хүн өөрийн шинжилгээний мэдээллээ гэрлэхийг хүсэгч нөгөө талдаа мэдэгдэнэ.

7.4.Гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь сэтгэцийн өвчтэй байсныг гэр бүл болсноос хойш мэдсэн тохиолдолд нөгөө этгээд гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болно.

8 дугаар зүйл.Гэрлэхэд харшлах шалтгаан

8.1.Дараах нөхцөл нь гэрлэхэд харшлах шалтгаан болно:

8.1.1.өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа;

8.1.2.гэрлэхийг хүсэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь энэ хуулийн 5.1-д заасан насанд хүрээгүй;

8.1.3.гэрлэхийг хүсэгчид гэр бүлийн, эсхүл төрөл, садангийн холбоотой;

8.1.4.гэрлэхийг хүсэгчид хоорондоо харгалзан дэмжигч, дэмжүүлэгч;

8.1.5.гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй;

8.1.6.энэ хуулийн 7.1-д заасан өвчтэй, халдвартай нь тогтоогдсон хүн өөрийн шинжилгээний мэдээллээ гэрлэхийг хүсэгч нөгөө талдаа мэдэгдээгүй;

8.1.7.гэрлэхийг хүсэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон.

9 дүгээр зүйл.Гэрлэгчдийн эрх, үүрэг

9.1.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд тэгш эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээж, хамтын шийдвэр гаргана.

9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах эрхтэй:

9.2.1.гэр бүлээ төлөвлөх;

9.2.2.оршин суух газраа сонгох;

9.2.3.сурах, ажил, мэргэжлээ сонгох;

9.2.4.хуваарьт эд хөрөнгөтэй байх;

9.2.5.хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах түүнээс олсон ашгийг тэгш хүртэх;

9.2.6.сайн дурын үндсэн дээр гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах;

9.2.7.гэрлэлтийн гэрээнд өөрөөр заагаагүй бол эхнэр, нөхөр нь өөрийн хувийн ашиг сонирхол, эд хөрөнгийн асуудлыг бие даан шийдвэрлэх;

9.2.8.эхнэр, эсхүл нөхөр нь нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эрүүл мэндэд гэм хор учруулсан, хуваарьт эд хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, гэмтээсэн бол хохирсон эхнэр эсхүл нөхөр Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу гэм хорыг арилгуулахыг шаардах;

9.2.9.гэр бүлийн хүчирхийллээс ангид байх.

9.3.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.3.1.гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах;

9.3.2.бие биеэ харилцан хүндэтгэх, халамжлах, дэмжин туслах, тэжээн тэтгэх, асран халамжлах;

9.3.3.гэр бүлийн бусад гишүүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

9.3.4.эрүүл хүүхэд төрүүлэхэд бэлтгэх, ургийн өсөлт, бойжилтыг тогтмол хянуулах;

9.3.5.угийн бичиг хөтлөх, өвлүүлэх;

9.3.6.бие биедээ үнэнч байх;

9.3.7.үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх;

9.3.8.гэр бүлийн үнэт зүйл, уламжлал, соёл, ёс заншлыг өвлүүлэх, хамгаалах.

9.6.Энэ зүйлийн 9.3.5-д заасан угийн бичиг хөтлөх журмыг соёлын болон хүн амын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгч нас барсан, эсхүл түүнийг нас барсан гэж зарласан;

10.1.2.гэрлэгчийг сураггүй алга болсонд тооцсон;

10.1.3.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.1.4.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу гэрлэгч хүйсээ өөрчилсөн.

10.2.Захиргааны журмаар гэрлэлтээ цуцлуулсан бол Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1-д зааснаар гэрлэлт дуусгавар болсон талаар бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн гэрлэлт дуусгавар болно.

10.3.Шүүхийн журмаар гэрлэлт цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж шүүх шийдвэрлэсэн өдрөөс эхлэн гэрлэлт дуусгавар болно.

Тайлбар: Энэ зүйлийн 10.1.4-т заасан хүйсийн өөрчлөлт хувь хүний хувийн болон эд хөрөнгийн эрхэд нөлөөлөхгүй бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах,

насанд хүрээгүй хүүхдийг аль нэг талын асрамжид үлдээх зэрэг маргаантай бол шүүхийн журмаар гэрлэлт цуцална.

11 дүгээр зүйл. Гэрлэлт цуцлах журам

11.1. Гэрлэлтийг хуульд заасан үндэслэлээр захиргааны болон шүүхийн журмаар цуцална.

11.2. Эхнэр нь жирэмсэн буюу эсхүл 2 насанд хүрээгүй хүүхэдтэй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн, хөдөлмөрийн чадвараа хагас, эсхүл бүрэн алдсан тохиолдолд гэрлэгчдийн хэн нэгний хүсэлтийн дагуу шүүх гэрлэлт цуцлахыг хориглоно.

11.3. Энэ зүйлийн 11.2-т заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлт цуцлах хүсэлт дахин гаргаж болно.

11.4. Гэрлэлт цуцлах шалтгаан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бол энэ зүйлийн 11.2-т заасан хамаарахгүй.

12 дугаар зүйл. Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах

12.1. Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа мэдэгдэж, гарын үсэг зурсан хүсэлтээ улсын бүртгэлийн байгууллага, эсхүл хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт гаргаж болно.

12.2. Улсын бүртгэлийн байгууллага, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар нь энэ зүйлийн 12.1-д заасан хүсэлтийг хянан үзэж 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцална.

12.3. Гэрлэгчид 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй, гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө бүртгүүлсэн бол гэрлэлтийг захиргааны журмаар цуцална.

13 дугаар зүйл. Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1. Захиргааны журмаар гэрлэлт цуцлахаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

13.2. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гэрлэгчдийн аль нэг нь гаргах эрхтэй.

13.3. Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тэргүүн ээлжинд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.4. Иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон гэрлэгчдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

13.5.Шүүх шаардлагатай гэж үзсэн бол гэрлэгчдийг эвлэрүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 129.1.7-д заасны дагуу тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.6.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн дэмжлэгийг авч, хамтран ажиллах, эсхүл магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

13.7.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, тэтгүүлэх, эсхүл хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, эд хөрөнгийн талаар дурдсан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед харилцан тохиролцож болно.

13.8.Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.

13.9.Энэ зүйлийн 13.8-д заасны дагуу хүүхдийн саналыг авахдаа сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын ажилтан, өмгөөлөгчийг байлцуулна.

13.10.Шүүх хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид байлгах талаар шийдвэрлэхдээ хүүхдийн хүсэл, сонирхол, амьдрах, сурах, хөгжихөд тааламжтай нөхцөлийг харгалзана.

13.11.Шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэртээ дараахь нөхцөлийг заавал тусгана:

13.11.1.хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх;

13.11.2.тусдаа амьдрах эцэг, эхийн хүүхэдтэй уулзах хугацаа, нөхцөл, тэтгэмжийн хэмжээ, нэмэлт зардал, сургалтын төлбөрийг хариуцах талаар тодорхой заах.

13.12.Гэрлэлтийг цуцлахад гэрлэгчдийн үрчлэн авсан болон дагавар хүүхэд гэрлэгчдээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлнэ.

13.13.Шүүх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх хүртэл насанд хүрээгүй хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын мэдэлд шилжүүлэх арга хэмжээ авна.

13.14.Гэрлэлт цуцалснаар хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах эцэг, эхийн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Хэрэв үүргээ биелүүлээгүй тохиолдолд сонирхогч тал шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

14 дүгээр зүйл.Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах

14.1.Гэрлэгчид буюу тэдгээрийн хэн нэгнийх нь хүсэлтээр шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа гэрлэлтийн гэрээ эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол хууль тогтоомжид заасны дагуу гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийг хувааж, хувиарлана.

14.2.Гэр бүлийн харилцаа дуусгавар болгосон шийдвэр гарсны дараа гэрлэгчид хамтын эд хөрөнгө олж аваагүй бол шүүх зөвхөн гэр бүлийн харилцаа дуусгавар болохоос өмнө эзэмшиж, өмчилж байсан дундын эд хөрөнгийг хувиарлана.

15 дугаар зүйл.Шүүхээр гэрлэлтийг цуцлах тусгай журам

15.1.Шүүх дараах тохиолдолд энэ хуулийн 13.5-д заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно:

15.1.1.гэрлэгчийн хэн нэгний хүчирхийлэл дарамтаас гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон;

15.1.2.гэрлэгчдийн хэн нэг нь сураггүй алга болсонд тооцсон;

15.1.3.гэрлэгчдийн хэн нэг нь эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан, эсхүл гурваас доошгүй жилээр хорих ялаар шийтгүүлсэн;

15.1.4.гэрлэгчдийн хэн нэг нь хүйсээ өөрчилсөн.

16 дугаар зүйл.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох

16.1.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасныг зөрчиж гэрлэсэн, гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлт бүртгүүлсэн бол гэрлэгчдийн хэн нэг, эсхүл эрх нь зөрчигдсөн гуравдагч этгээдийн нэхэмжлэлээр, эсхүл эрх бүхий байгууллагын санаачлагаар шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

16.2.Иргэний хуулийн 15.2-т заасан иргэний эрх зүйн бүрэн чадамжтай насанд хүрээгүй гэрлэгч гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцуулахыг зөвшөөрөөгүй, эсхүл түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих бол шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно.

16.3.Заналхийлэл, хүчирхийллийн улмаас, эсхүл хүсэл зоригийн эсрэг гэрлэлтээ батлуулсныг эрх бүхий байгууллага тогтоосон бол гэрлэлтийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

16.4.Эрх зүйн чадамжгүй хүнтэй гэрлэсэн гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай хэргийг шүүх хэлэлцэхдээ уг хэрэгт асран хамгаалах хувь хүн, байгууллагын хуулийн дагуу эрх олгогдон төлөөлөгчийг оролцуулна.

17 дугаар зүйл.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцоноос үүсэх үр дагавар

17.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцож, иргэний улсын бүртгэлд бүртгэнэ.

17.2.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд гэрлэгчдийн байгуулсан гэрлэлтийн гэрээ болон эд хөрөнгийн эрхтэй холбоотой бусад гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус болно.

17.3.Хэрэв гэрлэгчдийн хэн нэг нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдох үндэслэлийг нуун дарагдуулж, эсхүл хууран мэхэлж гэрлэсэн гэрлэлт нь хүчин

төгөлдөр бус гэж тооцогдох тохиолдолд энэ хуулийн хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гэрлэгч шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

17.4.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох тохиолдолд тухайн гэрлэлтээс төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй бөгөөд эцэг, эх хууль тогтоомжид заасан үүрэг хүлээнэ.

17.5.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл эрх ашиг нь зөрчигдсэн сонирхогч тал хохирлыг буруутай этгээдээс шаардаж болно.

18 дугаар зүйл.Гэрлэлт сэргээх

18.1.Талууд эвлэрснээ хамтран илэрхийлж, өргөдөл гаргасан бөгөөд өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй бол гэрлэлтийг гэрлэлт цуцлах шийдвэр гаргасан байгууллага сэргээнэ.

18.2.Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүн эргэн ирж, нөхөр, эсхүл эхнэртэйгээ хамтран амьдрах хүсэлтээ гаргасан бөгөөд нөхөр, эсхүл эхнэр нь өөр хүнтэй гэрлээгүй бол талуудын зөвшөөрснөөр шүүх гэрлэлтийг сэргээж болно.

18.3.Энэ зүйлийн 18.1, 18.2-т заасны дагуу шүүх гэрлэлтийг сэргээсэн шийдвэр гаргасан бол гэрлэлтийн хугацааг анх гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс тооцно.

19 дүгээр зүйл.Гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцох

19.1.Гэрлэгчид бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, ял эдлэхээс зайлсхийх, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах зорилгоор гэрлэлтээ цуцлуулсныг эрх бүхий байгууллагаас тогтоосон бол эрх нь зөрчигдсэн этгээдийн хүсэлтээр шүүх гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

20 дугаар зүйл.Гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүсэх үр дагавар

20.1.Гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж тооцно.

20.2.Гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноор гэрлэгчид энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.3.Энэ зүйлийн 22.1-д заасан тохиолдолд шүүх бусдад учирсан хохирлыг гэрлэгчдийн эд хөрөнгөөс Иргэний хуульд заасан журмаар гаргуулж нөхөн төлүүлнэ.

21 дүгээр зүйл.Гэрлэлттэй адилтгах харилцаа

21.1.Гэрлэлтээ бүртгүүлэгүй боловч, гэр бүлийн хэлбэрийг агуулсан дараах шаардлагыг хангасан 18-н насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүний хамтран амьдарч байгаа дараах харилцааг гэрлэлттэй адилтган үзнэ:

21.1.1.цаашид гэрлэлтээ бүртгүүлэх зорилготой;

21.1.2.хамтран амьдрагчид хоёулаа эсхүл хэн нэг нь өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх;

21.1.3.гурваас доошгүй жил тогтмол хамтран амьдарсан;

21.1.4.эд хөрөнгө дундаа өмчилж байгаа, хамтын хөрөнгө бий болгосон;

21.1.5.хамтран амьдрагчид нэг оршин суух хаягт бүртгэлтэй;

21.1.6.хамтран амьдрагчид хүүхэдтэй болсон.

21.2.Энэ зүйлийн 21.1-д шаардлага хангасан хамтран амьдрагчид хамтын амьдралын явцад эхнэр, нөхрийн адил эрх, үүрэг хүлээнэ.

21.3.Хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд хамтран амьдрагчдын хэн нэг нь дундын өмчийн хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг Иргэний хуульд заасны дагуу шаардах эрхтэй.

21.4.Хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх, өв залгаамжлах эрх, үүрэг үүсэхгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

22 дүгээр зүйл.Гэрлэлтийн гэрээ байгуулах журам

22.1.Гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулна.

22.2.Гэрлэлтийн гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрлэлт бүртгүүлсэн эсхүл гэрээ байгуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

22.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр үл хөдлөх эд хөрөнгийн эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болох, хязгаарлахаар зохицуулсан (эсхүл ийм харилцаа агуулсан) бол зохих журмын дагуу хөрөнгийн төрлөөс хамаарч Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

23 дугаар зүйл.Гэрлэлтийн гэрээний хэлбэр

23.1.Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэх, гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, эрх, үүргийг зохицуулах гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцож байгуулж болно.

23.2.Гэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгаж болно:

23.2.1.гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах;

23.2.2.гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох;

23.2.3.гэрлэлт дуусгавар болсны дараа гэр бүлийн гишүүдэд ногдох эд хөрөнгө болон хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгийг шилжүүлэх, хамтран өмчлөх, эсхүл хууль тогтоомжид зааснаар өөр нөхцөл тогтоох;

23.2.4.гэрлэгчид гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт цуцлагдсан, дуусгавар болсны дараа бие биенээ болон үр хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүргийг тодорхойлох;

23.2.5.гэрлэгчид гэрлэлт, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг энэ хуулийн 13.5-т зааснаас бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх;

23.2.6.гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах;

23.2.7.хууль тогтоомжоор харшлаагүй гэр бүлийн харилцааны бусад асуудал.

23.3.Гэрлэлтийн гэрээгээр дараах харилцааг зохицуулахыг хориглоно:

23.3.1.гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл дордуулсан;

23.3.2.гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл хөндсөн;

23.3.3.гэрлэгчид бие биеэ, насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх, сурах эрхийг хангах үүргээс чөлөөлсөн, эсхүл хязгаарласан;

23.3.4.эцэг, эх байх эрхийг хязгаарласан, хассан.

23.4.Гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, дуусгавар болгож болно.

23.5.Эхнэр, нөхөр хоёрын хэн нэгний гаргасан нэхэмжлэлийн дагуу гэрлэлтийн гэрээг шүүхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж, цуцалж, эсхүл бүхэлд нь хүчингүй болгож болно.

23.6.Гэрлэлтийн гэрээ, энэ хууль болон бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гэрлэлт цуцлагдсан өдрөөс гэрээ дуусгавар болно. Хэрэв гэрлэлтийн гэрээгээр гэрлэлт цуцалсны дараа талуудын хэрэгжүүлэх эрх, үүргийг тогтоосон бол тухайн эрх, үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХДЭД ОВОГ, НЭР ӨГӨХ, ХҮҮХДИЙН ОВОГ, НЭР, ЭЦЭГ /ЭХ/-ИЙН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ, ЭЦЭГ /ЭХ/-ИЙГ ТОГТООХ

24 дүгээр зүйл.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр

24.1.Эцэг, эх тохиролцсоны үндсэн дээр хүүхдэд овог, нэр өгнө.

24.2.Гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлийн эцэг нь нас барсан, гэрлэлт цуцлуулсан, эсхүл гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос хойш 10 сарын дотор төрсөн хүүхдэд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 6.8, 6.9-д заасны дагуу эцгийн овог, нэрээр бүртгүүлж болно.

24.3.Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах технологийг ашиглах гэрээ байгуулсны үндсэн дээр хүүхэд төрсөн бол хүүхдийн эцэг, эх харилцан тохиролцож хүүхдэд овог, нэр өгнө.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тодорхойгүй бол асрамжиндаа авч байгаа этгээд, эсхүл улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд овог, нэр өгч болно.

24.5.Үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн овог, өгсөн нэрийг авч болно.

24.6.Эцэг, эхийн хэн нэг нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол хүүхэд тухайн эцэг/эх/-ийн овог, өгсөн нэрийг авч болно.

24.7.Захиргааны журмаар хүүхдийн эцэг, эхийн нэрээр бүртгэсний дараа хүүхэд хойд эцэг/эх/-ээр овоглох хүсэлтэй бол бүртгэлийн байгууллагад овгоо өөрчлүүлэн бүртгүүлэх эрхтэй.

25 дугаар зүйл.Хүүхдийн овог, нэр, эцэг /эх/-ийн нэрийг өөрчлөх

25.1.Эцэг, эх гэрлэлтээ цуцалсан, эсхүл гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, эсхүл эцэг, эх байх эрхээ хасуулсан, үрчлэгдсэн бол асрамжид үлдэж байгаа эцэг /эх/-ийн нэрээр хүүхдийн овог, эцэг /эх/-ийн өөрчилж болно. Эцэг, эх гэрлэлтээ цуцалсан, эсхүл гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоны дараа эх нь гэрлэсэн бол хойд эцгийн нэрээр хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэрийг өөрчилж болно.

25.2.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахгүй бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, нэрийг Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу өөрчилж болно.

25.3.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэрийг өөрчлөх хүсэлтийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл 16 нас хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрын улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

25.4.Долоо, түүнээс дээш настай хүүхдийн овог, нэр, эцэг /эх/-ийн нэрийг өөрчлөх бол түүний саналыг авна.

25.5.Хүүхдийн овог, нэр, эцэг /эх/-ийн нэр өөрчилсөнтэй холбогдсон маргааныг хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, улсын бүртгэлийн байгууллагын хүсэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл.Хүүхдийн эцэг, эхийг захиргааны журмаар бүртгэх

26.1.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эх хамтран хүсэлт гаргасан бол улсын бүртгэлийн байгууллага, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар эцэг, эхийг бүртгэнэ.

27 дугаар зүйл. Хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох

27.1. Хүүхдэд овог, нэр өгөх, хүүхэд эцэг, эхийн нэр авахтай холбогдсон маргааныг сонирхогч талын хүсэлтийг үндэслэн хүүхдийн эцэг, эхийг шүүх тогтооно.

27.2. Эцэг, эхийг тогтоох маргааныг нотлох баримт, шүүхийн шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох

28.1. Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болохоор үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэйтэй гэрээ байгуулсны үндсэн дээр төрсөн хүүхдийн эцэг, эх байна.

28.2. Эхнэр, эсхүл нөхөр нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болохыг нөгөө талдаа зөвшөөрсөн бол тухайн хүүхдийн эцэг, эсхүл эхээр шууд тогтооно.

28.3. Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ байгуулсан гэрлэгчид үр хөврөлийн донорыг эцэг /эх/-ээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй.

28.4. Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ байгуулсан үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэй өөрийгөө эцэг, эхээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ, ЭЦЭГ, ЭХИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

29 дүгээр зүйл. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

29.1. Хүүхэд гэр бүлийн гишүүдийн нэгэн адил тэгш эрх эдэлнэ.

29.2. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд өсөж бойжих, асран хамгаалуулах, тэжээн тэтгүүлэх, сурч боловсрох, хөгжих, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, өв залгамжлах эрхтэй.

29.3. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд хандах үүрэгтэй.

29.4. Бүтэн өнчин, эцэг, эх нь хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах боломжгүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн бол хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан хамгаална.

30 дугаар зүйл. Эцэг, эх, хүүхдийн хооронд үүсэх эрх, үүрэг үүсэх

30.1.Хүүхэд төрснөөр, нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болсноор, эсхүл үрчлэн авснаар эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ.

30.2.Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлснээр дагавар хүүхэд, хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг үүснэ.

30.3.Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчдээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлнэ.

31 дүгээр зүйл.Насанд хүрээгүй эцэг, эхийн эрх, үүрэг

31.1.Эцэг, эх хоёулаа, эсхүл хэн нэг нь насанд хүрээгүй бол тэдгээрийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдох хүртэл төрсөн хүүхдийг асран хамгаалах, эсхүл харгалзан дэмжих үүрэг хүлээж болно.

31.2.Эцэг, эх хоёулаа, эсхүл хэн нэг нь насанд хүрээгүй бөгөөд асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл энэ зүйлийн 31.1-д заасан үүрэг хүлээхээс хүндэтгэн үзэх шалтгаанаар татгалзсан бол эцэг, эхийг эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдох хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага төрсөн хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилно.

32 дугаар зүйл.Эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлсэн эсэх, хамт амьдарч байгаа эсэхээс үл хамааран хүүхдийн өмнө харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

32.2.Эцэг, эх нь хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалж, хүүхэдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг авна.

32.3.Эцэг, эх хүүхдийн эрхийг хангахад дараах үндсэн үүрэг хүлээнэ:

32.3.1.хүүхдийн биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хүмүүжүүлэх, хоол хүнс, орон байр, хувцас, хичээлийн хэрэгсэл, тоглоом зэрэг сурах, хөгжихөд зайлшгүй шаардлагатай зүйлээр хангах;

32.3.2.хүүхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих, тэжээн тэтгэх;

32.3.3.төрөлх хэл, бичиг үсэг, суурь боловсрол эзэмшүүлэх;

32.3.4.хүүхдийн эд хөрөнгийг хамгаалах, зохистой захиран зарцуулах;

32.3.5.хүчирхийллээс ангид төлөвшүүлэх;

32.3.6.хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирох аргаар хүмүүжүүлэх;

32.3.7.хүүхдэдээ гэр бүлийн угийн бичиг өвлүүлэх, цус ойртолтоос үүсэх үр дагаврыг таниулах;

32.3.8.хүүхдээ бусдыг хүндлэх, ёс суртахуунд төлөвшүүлэх;

32.3.9.авьяас, хүсэл сонирхлыг нь дэмжих;

32.3.10.түүх, соёл, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх, байгаль эх дэлхийгээ хайрлах ухамсрыг төлөвшүүлэх;

32.3.11.хүүхэд эрхээ хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах;

32.3.10.хуульд заасан бусад үүрэг.

33 дугаар зүйл.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх

33.1.Хүүхдийн эцэг, эх нь түүний хууль ёсны төлөөлөгч бөгөөд иргэн, хуулийн этгээдийн өмнө хүүхдийг итгэмжлэлгүйгээр төлөөлж, хамгаална.

33.2.Хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй гэж үзвэл иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд хүүхдийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад, эсхүл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоолгохоор мэдэгдэнэ.

33.3.Энэ зүйлийн 33.2-т заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах этгээдийг томилох журмыг хууль зүйн болон гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

33.4.Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хохироосон, үүргээ биелүүлээгүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон гэр бүлийн бусад гишүүдэд энэ хууль болон бусад хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

34 дүгээр зүйл.Хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

34.1.Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт ажиллаж, сурч, амьдарч байгаа, хорих ял эдэлж байгаа, хугацаат цэргийн алба хааж байгаа болон бусад шалтгаанаар эцэг, эхийг энэ хуульд заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

34.2.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бүртгүүлээгүй хамтран амьдрагч байсан эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.

34.3.Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан, гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдарч байсан эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ байгуулж болно.

34.4.Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхэдтэй хамт амьдрах эцэг, эсхүл эх, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхдүүдтэйгээ харилцах, тэднийг хүмүүжүүлэхэд хүлээх үүрэг, олгох тэтгэлгийн хэмжээг тохиролцож болно.

34.5.Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, дордуулах нөхцөлийг тохиролцохыг хориглоно.

34.6.Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээг эцэг, эх бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ.

34.7.Энэ зүйлийн 34.4, 34.5-т заасан гэрээний нөхцөлтэй холбогдох маргааныг шүүх шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл.Эцэг, эх болон хүүхдийн эд хөрөнгийн харилцаанд холбогдох эрх, үүрэг

35.1.Эцэг, эх насанд хүрээгүй хүүхэд болон насанд хүрсэн боловч байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ.

35.2.Эцэг, эх, эсхүл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч 14 насанд хүрээгүй хүүхдийнхээ өмнөөс эд хөрөнгө, ажил хэргийн хэлцэл хийх, 14-өөс 18 хүртэлх насны хүүхэдтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх, түүнчлэн хүүхдийг эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдох хүртэл нь эд хөрөнгийг зохистой захиран зарцуулах эрх эдэлнэ.

35.3.Эцэг, эх хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эд хөрөнгө, ажил хэргийг зохих ёсоор удирдаж, эд хөрөнгийг хэвээр хадгалах, боломжтой бол нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ.

35.4.Эцэг, эх, эсхүл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах асуудлаар шийдвэр гаргаж болно:

35.4.1.хүүхдийн өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах, худалдах, шилжүүлэх, хуваах;

35.4.2.хүүхдийн өв залгамжлагдсан эд хөрөнгө болон өөрийн хөдөлмөрөөр олж эд хөрөнгийг захиран зарцуулах, эсхүл өр төлбөр төлөх;

35.4.3.хүүхдийн нэрийн өмнөөс өв залгамжлалаас татгалзах, болзолтойгоор өвийг хүлээн авах;

35.4.4.хүүхдийн нэрийн өмнөөс хүүхдийн эд хөрөнгөд хохирол учруулах, хорогдуулах хэлцэл хийх;

35.4.5.хүүхдийг бэлэг (бэлэглэлийн гэрээ) авахаас татгалзах;

35.4.6.хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд харшлах бусад хэлцэл хийх.

35.5.Хүүхэд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны хойд эцэг, /эх/-ийн нэрээр овоглосон тохиолдолд төрсөн хүүдийн адил эрх эдэлж, хойд эцэг, /эх/-ийн эд хөрөнгийг өв залгамжлах эрх үүснэ.

36 дугаар зүйл.Хүүхдийн эд хөрөнгийг зохицуулахад эцэг, эхийн эрхийг хязгаарлах

36.1.Хүүхдийн эд хөрөнгөөс **олсон орлогыг** хүүхдийг тэжээн тэтгэх болон гэр бүлийн хэрэгцээнд зарцуулахаас бусад зорилгоор зарцуулахыг хориглоно.

36.2.Эцэг, эх, асран хамгаалагч, эсхүл тэдгээрийн хэн нэг нь хүүхдийн эд хөрөнгөд эрсдэл учруулсан тохиолдолд эрх бүхий этгээд хүүхдийн эд хөрөнгийн тооллого хийх, тайлан гаргахыг шаардах эрхтэй.

36.3.Шүүх асран хамгаалах байгууллага, прокурор, эцэг, эхийн хэн нэгнийх нь нэхэмжлэлээр гэм буруутай эцэг, эхийг хүүхдийн эд хөрөнгийг зохицуулах эрхийг хязгаарлаж, цуцалж болно.

37 дугаар зүйл. Хүүхэд эцэг, эх бусад төрөл садантайгаа харилцах эрх

37.1. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид хориглосноос бусад тохиолдолд хүүхэд эцэг, эх, төрөл, садантайгаа харилцах эрхтэй.

37.2. Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, тусдаа амьдардаг болон бусад шалтгаанаар хүүхдийн энэ зүйлийн 37.1-д заасан эрхийг хязгаарлахыг хориглоно.

37.3. Эцэг, эхийн хэн нэг нь хүүхдийн төрөл садантайгаа харилцах эрхийг хязгаарласан тохиолдолд хүүхэд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, ажилтанд хандан шүүхээр эрхээ хамгаалуулна.

37.4. Хүүхдийн төрөл, садантайгаа харилцахыг хязгаарласан талаар маргааныг шүүх шийдвэрлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргасан хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

37.5. Хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх журмыг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

37.6. Шүүх энэ зүйлийн 37.4-д зааснаас гадна хүүхдийн төрөл, садантайгаа харилцах эрхийг хязгаарласан тухай маргааныг шийдвэрлэхдээ долоогоос дээш насны хүүхдийн саналыг харгалзана.

38 дугаар зүйл. Эцэг, эх байх эрхийг хязгаарлах

38.1. Эцэг, эх байх эрхийг дараах тохиолдолд гурваас есөн сар хүртэл хугацаагаар шүүхийн шийдвэрээр хязгаарлаж болно:

38.1.1. хүүхдийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд оруулсан;

38.1.2. хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалах талаар хуульд заасан үүргээ биелүүлээгүй, орон сууц, хувцас, хоол хүнс, бусад ахуйн хэрэглээгээр санаатайгаар хангаагүй, гачигдуулсан;

38.1.3. хүүхдийн хөдөлмөрийг зүй бусаар ашигласан;

38.1.4. хүүхдийг үл хайхарсан, эсхүл дарамталсан.

38.2. Эцэг, эх байх эрхийг хязгаарлах тухай нэхэмжлэлийг шүүхэд хэлэлцэх хугацаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэж үзвэл шүүх хүүхдийг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын асран хамгаалалтад шилжүүлж болно.

39 дүгээр зүйл. Эцэг, эх байх эрх хязгаарласнаас үүсэх үр дагавар

39.1. Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн тухайн хүүхдийг биечлэн өсгөн

хүмүүжүүлэх, төлөөлөх, хүүхэдтэй холбогдох хууль тогтоомжоор олгосон эрхээ энэ хуулийн 38.1-д заасан хугацаанд алдана.

39.2.Шүүх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүнээс хүүхдийг тэжээн тэтгэхэд шаардагдах тэтгэлгийг гаргуулах асуудлыг шийдвэрлэнэ.

39.3. Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, төрөл садангийн хүнгүй, эсхүл тэдгээр нь асран хамгаалах, харгалзан дэмжихээс татгалзсан бол шүүх **хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын асран хамгаалалтад** тухайн хүүхдийг **энэ хуулийн 38.1-д заасан заасан хугацаагаар шилжүүлнэ.**

39.4.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн энэ хуулийн 38.1-д заасан нөхцөл байдлыг арилгаагүй тохиолдолд сонирхогч тал тухайн хүний эцэг, эх байх эрхийг хасуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

39.5.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүний хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхгүй хэвээр үлдэнэ.

39.6.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 39.3-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал болон хүүхдэд учирсан хохирлыг буруутай этгээдээс гаргуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

39.7.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулснаас үл хамааран хүүхдийн өв залгамжлах, эд хөрөнгийн эрх хэвээр хадгалагдана.

39.9.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

40 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрх хязгаарласныг дуусгавар болсонд тооцох

40.1.Энэ хуулийн 38.1-д заасан нөхцөл байдал арилсан бол эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүний хүсэлтийг шүүх хянан үзэж, эцэг, эх байх эрх хязгаарласныг дуусгавар болсонд тооцох тухай шийдвэр гаргана.

40.2.Энэ хуулийн 38.1-д заасан нөхцөл байдал арилаагүй, эсхүл хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол шүүх эцэг, эх байх эрх хязгаарласныг дуусгавар болгох хүсэлтийг хэрэгсэхгүй болгож болно.

40.3.Шүүх эцэг, эх байх эрх хязгаарласныг хүчингүй болсонд тооцох тухай шийдвэр гаргахдаа хүүхэд долоон нас хүрсэн бол түүний саналыг харгалзана.

41 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрхийг хасах

41.1.Эцэг, эх байх эрхийг дараах тохиолдолд хасна:

41.1.1.энэ зүйлийн 38.1-д заасан нөхцөл байдал хүндэрсэн, удаа дараа давтагдсан, хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалах үүргээ ноцтой зөрчсөн;

41.1.2.согтууруулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис байнга хэрэглэдэг;

41.1.3.хүүхдийн эсрэг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.8-д заасан хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн.

41.2.Эцэг, эх байх эрхийг хасах тухай нэхэмжлэлийг сонирхогч тал шүүхэд гаргаж болно.

41.3.Эцэг, эх байх эрхийг хасах тухай нэхэмжлэлийг шүүхэд хэлэлцэх хугацаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэж үзвэл шүүх хүүхдийг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын асран хамгаалалтад шилжүүлж болно.

41.4.Эцэг, эх байх эрхийг хассан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор шүүх улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

42 дугаар зүйл.Эцэг, эх байх эрх хассанаас үүсэх үр дагавар

42.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан этгээд хүүхдийг төлөөлөх, биечлэн өсгөн хүмүүжүүлэх, хүүхэдтэй холбогдох тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг авах, хөнгөлөлт эдлэх болон хууль тогтоомжоор олгосон бусад эрхийг эдлэхгүй.

42.2.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан бол хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор шүүх дараах арга хэмжээг авна:

42.2.1.садан, төрлийн хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох;

42.2.2.төрөл, садангийн хүн байхгүй, эсхүл тэдгээр нь татгалзсан бол гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын асран хамгаалалтад шилжүүлэх.

42.3.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараах арга хэмжээ авна:

42.3.1.хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх;

42.3.2.эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан бол хүүхдийг үрчлүүлэх, хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах.

42.4.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 42.3-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал болон хүүхдэд учирсан хохирлыг буруутай этгээдээс гаргуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

42.5.Эцэг, эхийн хэн нэг, эсхүл хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан эсэхээс үл хамааран хүүхдийн өв залгамжлах, эд хөрөнгийн эрх хэвээр хадгалагдана.

42.6.Эцэг, эх байх эрхээ хасуулсан нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд шүүх хариуцагч этгээдээс хүүхдийг тэжээн тэтгэхэд шаардагдах тэтгэлгийг гаргуулна.

43 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах

43.1.Энэ хуулийн 38, 41 дүгээр зүйлд заасны дагуу эцэг, эх байх эрхийг нь хязгаарласан, хассан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас уг хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулна.

43.2.Шүүх эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан этгээдийн эрхийг сэргээхдээ зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан эсэхийг харгалзана.

43.3.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулна.

44 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрхийг сэргээх

44.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн энэ хуулийн 38.1, 41.1.1-41.1.2-т заасан нөхцөл байдлыг арилгасан тохиолдолд эцэг, эх байх эрхээ сэргээлгэх хүсэлтийг шүүхэд гаргана.

44.2.Шүүх эцэг, эх байх эрхийг сэргээх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ 14 насанд хүрсэн хүүхдийн санал, эрх бүхий байгууллагаас хийсэн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан үзнэ.

44.3.Шүүх дараах тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээхгүй:

44.3.1.хүүхэд үрчлэгдсэн;

44.3.2.энэ хуулийн 41.1.3-т заасан хүчирхийлэл үйлдсэн;

44.3.3.эцэг, эх байх эрхийг сэргээх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар байгаа нь тогтоогдсон.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТЭЖЭЭН ТЭТГЭХ, ТЭТГҮҮЛЭХ

45 дугаар зүйл.Тэжээн тэтгүүлэх эрх, тэжээн тэтгэх үүрэг

45.1.Тэжээн тэтгэх үүрэг бүхий этгээд /цаашид “тэтгэлэг төлөгч” гэх/ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн, татгалзсан, тэжээн тэтгэх тухай гэрээний үүргээ биелүүлээгүй бол тэжээн тэтгүүлэх эрхтэй болсон этгээд/ цаашид “тэтгэлэг авагч” гэх/ тэжээн тэтгүүлэх эрх үүссэн цагаас хойш хугацаа харгалзахгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

45.2.Гэр бүлийн гишүүд, гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эх, төрлийн хүмүүсээ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй.

45.3.Тэтгэлэг төлөгч тэтгэлэг авагчид хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, гэрээнд заасан тэтгэлэг төлөх үүрэгтэй.

45.4.Тэтгэлэг төлөгч тэтгэлэг авагчид хууль тогтоомж, хэрэв байгаа бол гэрээнд заасан тэтгэлэг төлөх үүрэгтэй.

46 дугаар зүйл. Гэрлэгчдийн бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг

46.1. Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүргээ хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулж болно.

46.2. Гэрлэгчдийн хэн нэг нь бие биеэ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхээс татгалзсан, эсхүл тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал (зохигч) нь тэжээн тэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

47 дугаар зүйл. Гэрлэлтээ цуцлуулсан эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх

47.1. Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэр дараах тохиолдолд **тэжээн тэтгүүлэх буюу тэтгэлэг авахаар** шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

47.1.1. гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө төрсөн, үрчлэн авсан гурван нас хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа;

47.1.2. гэрлэлт цуцлахаас өмнө, эсхүл гэрлэлт цуцлагдсанаас хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий болсон нөхцөл байдалтай шууд холбоотой үүссэн.

47.2. Шүүх гэрлэлтээ цуцлуулсан этгээдийн эд хөрөнгө болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэтгэлгийн хэмжээг энэ хуулийн 49.1, 49.2-т заасны дагуу тогтооно.

48 дугаар зүйл. Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг

48.1. Эцэг, эх нь насанд хүрээгүй, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй нь тогтоогдсон хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

48.2. Эцэг, эх нь энэ зүйлийн 48.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол сонирхогч тал шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

48.3. Эцэг, эхийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах үедээ хүүхдийн тэтгэлэг авахаас татгалзсан нь хариуцагчийг хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

48.4. Төрүүлсэн, эсхүл үрчлэн авсан эцэг, эх, хойт эцэг, эх нь өндөр настан болсон, эрүүл мэндийн бусад шалтгаанаар хүүхдээ тэжээн тэтгэх боломжгүй болсон бол гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, ажилтны санал, дүгнэлтийг үндэслэн хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ.

49 дүгээр зүйл. Тэтгэлгийн хэмжээ, олгох хугацаа, хэлбэр

49.1. Шүүх тэтгэлгийн хэмжээг сард нэгээс доошгүй удаа тэтгэлэг төлөгчийн орлого, хэрэгцээ шаардлага зэрэг нөхцөл байдлыг харгалзан гэр бүлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу тогтооно.

49.2.Цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.

49.3.Хуульд зааснаас өөрөөр тэтгэлгийн хэмжээг талууд тэжээн тэтгэх тухай гэрээгээр тохиролцож болно. Гэрээгээр тохиролцсон тэтгэлгийн хэмжээ энэ зүйлийн 49.1-д зааснаас бага байж болохгүй.

49.4.Хүүхдийн тэтгэлгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 90, 91 дүгээр зүйлд заасан журмын дагуу гаргуулж олгоно.

49.5.Хүүхдийн тэтгэлгийг хүүхдийн хэрэгцээнд зарцуулаагүй нь тогтоогдсон бол тэтгэлэг төлөгч, 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө, эсхүл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан, ажилтан шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

49.6.Хүүхдийн тэтгэлгээс бусад тэтгэлэг олгох хэлбэр, хугацааг шүүх, эсхүл тэжээн тэтгэх тухай гэрээгээр тогтоож болно.

49.7.Тэтгэлэг олгох хэлбэр, хугацааг шүүх, эсхүл энэ хуулийн 51.1-д заасан тэжээн тэтгэх тухай гэрээгээр тогтоож болно.

50 дугаар зүйл.Тэтгэлэг төлөгчөөс нэмэлт тэтгэлэг, зардал гаргуулах

50.1.Тэтгэлэг авагч өвчилсөн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, байнгын асаргаа шаардлагатай, сургуульд орсон зэрэг онцгой тохиолдолд тэтгэлэг төлөгчөөс нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл зардлыг хариуцуулахаар тэтгэлэг авагч өөрөө, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

50.2.Нэмэлт тэтгэлэг, эсхүл зардлын хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө, санхүүгийн нөхцөл байдал, тэтгэлэг авагчийн бодит шаардлагад нийцсэн байна.

50.3.Энэ зүйлийн 50.1-д заасан тэтгэлэг авагчид үүссэн нөхцөл байдал арилсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нэмэлт тэтгэлэг, эсхүл зардлыг зогсоох асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

51 дүгээр зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүйд тооцох

51.1.Тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч нь тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцож, тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулж болно.

51.2.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах хүчингүйд тооцох асуудлыг Иргэний хуульд заасан гэрээнд тавигдах үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

51.3.Тэжээн тэтгэх тухай гэрээг талууд харилцан тохиролцож, байгуулж, нэмэлт, өөрчлөлт оруулж, цуцалж болно.

51.4.Шүүх тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах асуудлаар гарсан маргааныг талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол, эд хөрөнгө, санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.

52 дугаар зүйл.Тэтгэлэг авагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох

52.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ нь хүүхэд, эсхүл гэр бүлийн насанд хүрсэн иргэний эрх зүйн чадамжгүй гишүүний хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол сонирхогч тал шүүхэд гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэл гаргана.

52.2.Шүүх тэжээн тэтгэх тухай гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол талууд дахин гэрээ байгуулж болно.

52.3.Энэ зүйлийн 52.2-т заасны дагуу талууд дахин гэрээ байгуулахгүй бол тэжээн тэтгэх нөхцөлийг шүүх шийдвэрлэнэ.

53 дугаар зүйл.Шүүхээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх болон тэтгэлэг төлөхөөс чөлөөлөх

53.1.Тэтгэлэг төлөх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө, орлого, гэр бүлийн нөхцөл байдал өөрчлөгдсөн, тэтгэлэг авагч эсхүл өөрөө хангалттай орлоготой бол талуудын хэн нэг нь тэтгэлгийн хэмжээг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

53.2.Тэтгэлэг авагч нь тэтгэлэг төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, гэр бүлийн гишүүнийг байнгын хүчирхийлэл дарамтанд оруулж, гэм хор учруулсан, учруулахаар завдсан нь шүүхээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээрээр чөлөөлнө.

54 дүгээр зүйл.Тэтгэлэг нөхөн төлөхөөс чөлөөлөх

54.1.Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлөгдөөгүй тэтгэлгийг талууд харилцан тохиролцож төлбөрийн хэмжээг бууруулах, эсхүл нөхөн төлөхөөс чөлөөлж болно.

54.2.Тэтгэлэг төлөгч этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэлэг төлөөгүй болох нь тогтоогдсон, түүнчлэн түүний эд хөрөнгө, санхүүгийн болон гэр бүлийн нөхцөл байдлаас шалтгаалж тэтгэлгийг нөхөн төлөх боломжгүй гэж шүүх үзвэл тэтгэлгийн хэмжээг багасгах, эсхүл чөлөөлж болно.

54.3.Энэ зүйлийн 54.1, 54.2-т зааснаас бусад тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсноор тэтгэлэг төлөгч тэтгэлэг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөнө.

ДОЛДУГААР БҮЛЭГ АСРАН ХАМГААЛАХ, ХАРГАЛЗАН ДЭМЖИХ

55 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих

55.1.Эцэг, эх, хүүхэд, гэр бүлийн гишүүнээ асран хамгаалах, харгалзан дэмжихэд энэ бүлэг хамаарахгүй.

55.2.Асран хамгаалалтад дараах хүнийг хамруулна:

55.2.1.14 насанд хүрээгүй бүтэн өнчин хүүхэд;

55.2.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон 14 насанд хүрээгүй хүүхэд;

55.2.3.эцэг, эх нь хоёулаа энэ хуульд заасны дагуу эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

55.2.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн асран хамгаалах, хүмүүжүүлэх боломжгүй байгаа 14 насанд хүрээгүй хүүхэд;

55.2.5.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эх нь хорих газарт ял эдэлж байгаа 14 насанд хүрээгүй хүүхэд;

55.2.6.эцэг, эх нь тодорхойгүй, эсхүл эцэг, эх нь сураггүй алга болсонд тооцогдсон асран хамгаалалтгүй байгаа 14 насанд хүрээгүй хүүхэд;

~~55.2.7.сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй гэж төөцөгдсөн хүн;~~

55.2.8.ганц бие, төрөл садангүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан;

55.2.9.гэр бүлийн гишүүд бие биеэ асран хамгаалах боломжгүй, төрөл, садангийн хүнгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настан.

55.3.Харгалзан дэмжлэгт дараах хүнийг хамруулна:

55.3.1.14-өөс дээш насны бүтэн өнчин хүүхэд;

55.3.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон 14-өөс дээш насны хүүхэд;

55.3.3.энэ хуульд заасны дагуу эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний 14-өөс дээш насны хүүхэд;

55.3.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байдаг зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар биечлэн асран хүмүүжүүлэх боломжгүй байгаа 14-өөс дээш насны хүүхэд;

55.3.5.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эх нь хорих газарт ял эдэлж байгаа 14-өөс дээш насны хүүхэд;

55.3.6.эцэг, эх нь тодорхойгүй, эсхүл эцэг, эх нь сураггүй алга болсонд тооцогдсон харгалзан дэмжигчгүй болсон 14-өөс дээш насны хүүхэд;

55.3.7.согтууруулах ундаа, мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх эм, бодис байнга хэрэглэсний улмаас эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн;

55.3.8.эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн.

55.4.Ах, эгч, дүү нарт нэг асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтооно. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн өөр, өөр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоож болно.

55.5.Эцэг, эх нь хоёулаа нас барсан, сураггүй алга болсон, иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй нь тогтоогдсон, эцэг, эх байх эрхээ хасуулсан, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтооход төрөл, садангийн хүн давуу эрх эдэлнэ.

56 дугаар зүйл.Асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эрх

56.1.Асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүн дараах эрхтэй:

56.1.1.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гэр бүлд хамт амьдрах;

56.1.2.эрүүл, аюулгүй орчинд амьдрах;

56.1.3.сурч боловсрох нөхцөлөөр хангуулах;

56.1.4.хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг бусад олговор авах, хуримтлал, өөрийн эд хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл авах, хүсэлт гаргах, шаардах;

56.1.5.эд хөрөнгө эзэмших, өмчлөх эрхээ хадгалах;

56.1.6.хуульд заасан бусад эрх.

57 дугаар зүйл.Асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон хүнийг илрүүлэх, бүртгэх, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах

57.1.Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон хүний талаар тухайн орон нутгийн байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.

57.2.Энэ зүйлийн 57.1-д заасан хүний талаар мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон иргэний анхан шатны лавлагаа, мэдээллийг хийж, холбогдох байгууллагад шилжүүлэн шаардлагатай үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна.

58 дугаар зүйл.Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийн хэлбэр, түүнийг тогтоох

58.1.Энэ хуулийн 55.2, 55.3-т заасан асран хамгаалалт, харгалзан дэмжлэг шаардлагатай хүн өөрөө, эсхүл төрөл, садангийн хүн, иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд тухайн орон нутгийн байгууллагад бичгээр хүсэлт гаргана.

58.2.Энэ хуулийн 55.2, 55.3-т заасан хүний зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээг аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага хийж, дүгнэлт, мэдээллийг аймаг, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

58.3.Аймаг, сум, дүүргийн Засаг дарга энэ зүйлийн 58.2-т заасан дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээ авна:

58.3.1.төрөл, садангийн хүний бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох;

58.3.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч байхгүй, сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн, ганц бие, төрөл садангүй, эсхүл бие биеэ асран хамгаалах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, түүний гэр бүлийн гишүүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх.

58.4.Аймаг, сум, дүүргийн Засаг дарга энэ зүйлийн 58.3-т заасан арга хэмжээг авахдаа асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг тогтоож, гэрээ байгуулан биелэлтэд хяналт тавина. Эд хөрөнгө эрхлэх, хамгаалахтай холбоотой гарах зардлыг асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эд хөрөнгөөс гаргаж болно.

58.5.Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүний нөхцөл байдлын үнэлгээ, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон шийдвэр, гэрээ, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн төвийн дүгнэлт, оршин суугаа газрын хаяг, төрөл, садангийн хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, бусад бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэг нээж, бүрдүүлнэ.

58.6.Эрүүл мэндийн байдал, өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ өөрөө хэрэгжүүлж чадахгүй болсон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн асрамжид байсан хүнд шинээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоохдоо энэ зүйлийн 58.3, 58.4-т заасныг баримтална.

58.7.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн буруутай үйл ажиллагаанаас асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, санхүүгийн нөхцөл байдалд хохирол учирсан бол гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана.

58.8.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэнийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөнө.

58.9.Энэ хуульд харшлахгүй бол гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэнд тухайн улсын хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон шийдвэрийг хүчинтэйд тооцно.

59 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хориглох этгээд (хүн)

59.1.Дараах дурдсан хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хориглоно:

59.1.1.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан;

59.1.2.өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;

59.1.3.сүрьеэ, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой, сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис байнга хэрэглэдэг;

59.1.4.хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн;

59.1.5.өөрийн буруугаас үрчлэлтийг хүчингүйд тооцуулсан;

59.1.6.асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон.

60 дугаар зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хориглох зүйл

60.1.Хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ хуулийн 32, 33, 35.1-35.3-т зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

60.1.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хоол, хүнс, орон сууцаар хангах, асран сувилах;

60.1.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

60.1.3.гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гэрээний дагуу тайлагнах.

60.2.Хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах үйлдэл хийхийг хориглоно:

60.2.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнтэй хэлцэл хийх;

60.2.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнтэй хэлцэл хийх;

60.2.3.асрамж, дэмжлэгтээ байгаа хүн болон өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүний хооронд үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлэхэд тухайн хүнийг төлөөлөх.

61 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн харилцаа дуусгавар болох

61.1.Асран хамгаалуулагч хүүхэд 14 насанд хүрмэгц асран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

61.2.Дараах тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг дуусгавар болно:

61.2.1.хүүхдийг эцэг, эхэд нь хууль тогтоомжид заасан үндэслэлээр буцаасан;

61.2.2.асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийг гэр бүлд нь буцаасан;

61.2.3.асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлсэн;

61.2.4.хүүхдийг үрчлүүлсэн;

61.2.5.асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгч 18 насанд хүрсэн;

61.2.6.асран хамгаалагч асран хамгаалах харилцааг дуусгавар болгох хүсэлт гаргасан;

61.2.7.шүүхийн шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцсон;

61.2.8.асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүн сураггүй алга болсон, эсхүл нас барсанд тооцогдсон, нас барсан;

61.2.9.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг шүүх хүчингүй болгосон;

61.2.10.асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

61.3.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эрхээ урвуулан ашигласан, хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр шүүх асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, хохирлыг нөхөн төлүүлнэ.

61.4.Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөгдсөн этгээд асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан хүний эд хөрөнгийн тайланг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, эд хөрөнгийг өөрт нь, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өв залгамжлагчид 30 хоногийн дотор шилжүүлнэ.

62 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа

62.1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг иргэн гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж /цаашид “асран хүмүүжүүлэх гэр бүл” гэх/ болно.

62.2.Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд хугацаатай гэрээ байгуулна.

62.3.Энэ хуулийн 59.1-д заасан хүний гэр бүлтэй асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хориглоно.

62.4.Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад хөнгөлөлт, гэрээ дуусгавар болох хугацаа, үндэслэл, үр үр дагавар болон бусад холбогдох асуудлыг тусгана.

62.5.Хүүхдийг асран хүмүүжүүлэхэд тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл бий болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан /өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ бий болсон бол асран хүмүүжүүлэгчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

62.6.Долоон насанд хүрсэн хүүхдийг асран хүмүүжүүлэх гэр бүлд шилжүүлэхдээ хүүхдийн өөрийнх саналыг харгалзана.

62.7.Асран хүмүүжүүлэх гэр бүлд шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах болон хууль тогтоомжийн дагуу бусад эрх эдэлнэ.

62.7.Асран хүмүүжүүлэх гэр бүлийг сонгон шалгууруулах, ажиллах, хяналт тавих журмыг Хүүхэд хамгааллын тухай хуулиар зохицуулна.

63 дугаар зүйл.Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүүхдэд олгох тэтгэмж, тэтгэлэг, түүнтэй адилтгах орлогыг зарцуулах

63.1.Асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүүхдийг тэжээн тэтгэхэд зориулан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу мөнгөн тэтгэмж олгоно.

63.2. Төрөл, садангийн хүний болон гэр бүлийн асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүүхдэд эцэг, эхээс олгох тэтгэлэг болон төрөөс олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, бусад олговрын эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээнээс бусад тохиолдолд 60 хүртэл хувийг хүүхдийн хэрэгцээнд зарцуулж, үлдэх хэсгийг хүүхдийн нэр дээрх хадгаламжийн дансанд хуримтлуулна.

63.3.Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдэд эцэг, эхээс олгох тэтгэлэг болон төрөөс олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж болон бусад олговрыг хүүхдийн нэр дээрх хадгаламжийн дансанд хуримтлуулна.

63.4.Энэ зүйлийн 63.1, 63.2-т заасан хүүхдийн тэтгэлэг, тэтгэмжийг зарцуулах, хяналт тавих журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

64 дүгээр зүйл.Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүүхдийн эд хөрөнгийг зарцуулах, хамгаалах

64.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн хуваарьт эд хөрөнгийг хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн түүний боловсрол,

эрүүл мэнд, хүмүүжил, соёл, ахуйн хэрэгцээг хангахад зориулан захиран зарцуулж болно.

64.2.Хүүхдийн хуваарьт эд хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө, мөнгөн хуримтлалыг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн нэр дээр бүртгүүлэх, хадгалуулах үүрэг хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ҮРЧЛЭХ

65 дугаар зүйл.Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх зарчим, нөхцөл

65.1.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон энэ хуулийн 67.1-д заасны дагуу Үрчлэлийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

65.2.Үрчлэлт нь талуудын сайн дурын үндсэн дээр хийгдэх бөгөөд үрчлэлтийн харилцаанд дараах зарчмыг баримтална:

65.2.1.хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах;
65.2.2.эцэг, эх төрүүлсэн хүүхдээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бусдад үрчлүүлэхгүй байх;

65.2.3.долоо ба түүнээс дээш насны хүүхдийн саналыг харгалзах;
65.2.4.үрчлэгч болон үрчлүүлэх хүүхдийн насны зөрүү нь 22-оос доошгүй байх;

65.2.5.төрсөн ах, эгч дүү, ихэр хүүхэд биш бол нэг удаа нэг хүүхэд үрчлүүлэх;

65.2.6.нэг гэр бүлд хүүхэд дахин үрчлүүлэх хугацаа гурван жилээс доошгүй байх.

65.3.Төрсөн ах /эгч/ дүү, ихэр хүүхдийг нэг гэр бүлд үрчлүүлнэ. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахгүй бол хүүхдийг төлөөлөх этгээдийн зөвшөөрлийг үндэслэн өөр өөр гэр бүлд үрчлүүлж болно.

65.4.Үрчлэгч нь хүүхдийн төрөл, садангийн хүн бол энэ хуулийн 66.3.2-т заалт хамаарахгүй.

65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг хийж Зөвлөлд хүргүүлнэ.

65.6.Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

65.7.Ашиг хонжоо олох зорилгоор хүүхэд үрчлэхтэй холбоотой үрчлэлтийн үйл ажиллагаа эрхлэх, зуучлахыг хориглоно.

66 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

66.1.Үрчлэгч нь эцэг, эхийн адил энэ хуулийн 32, 33, 35.1-35.3, Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

66.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн болон эдийн засгийн бүрэн чадамжтай этгээд байна.

66.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

66.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;

66.3.2.60-аас дээш настай ганц бие хүн;

66.3.3.хоёр, түүнээс дээш удаа гэрлэлтээ цуцлуулж байсан;

66.3.4.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон;

66.3.5.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан;

66.3.6.өөрийн буруугаас үрчлэлтийг хүчингүйд тооцуулсан;

66.3.7.сүрьеэ, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис байнга хэрэглэдэг;

66.3.8.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргээ биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон;

66.3.9.гэр бүлийн хүчирхийлэлийн хэргээр эрүүгийн ялаар шийтгэгдэж байсан, эсхүл эрүүгийн хэрэгт хорих ялаар шийтгэгдэж байсан, эсхүл хорих ял эдэлж байгаа;

66.3.10.гэр бүлийн зөрчлийн хэргээр баривчлах шийтгэлээр шийтгэгдэж байсан;

66.3.11.орон байргүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг;

66.3.12.хууль бусаар хүүхдийг ажил, хөдөлмөр эрхлүүлж байсныг эрх бүхий байгууллага тогтоосон;

66.3.13.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан;

66.3.14.орлогогүй болсон.

67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэх журам

67.1.Хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллана. Үрчлэлийн зөвлөлийн ажиллах журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.2.Шүүх Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

67.3.Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгчийг гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

67.4.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийг үрчлэн авах тухай шүүхийн шийдвэр гарахаас өмнө хүүхдээ үрчлүүлэх зөвшөөрлөө цуцлах эрхтэй.

67.5.Хүүхэд үрчлүүлэх эцэг, эхийн зөвшөөрлийг зөвхөн хүүхэд төрсний дараа өгнө.

67.6.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дараа үрчлүүлж болно.

68 дугаар зүйл.Эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр хүүхэд үрчлүүлэх

68.1.Дараах тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг үрчлүүлж болно:

68.1.1.эцэг, эх нь хоёулаа нас барсан, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй;

68.1.2.эцэг, эх нь хоёулаа сэтгэцийн өвчтэй, хүүхдээ асрах боломжгүй нь тогтоогдсон;

68.1.3.шүүхээс эцэг, эхийг сураггүй алга болсонд тооцсон;

68.1.4.эцэг, эх хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан;

68.1.5.эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон.

69 дүгээр зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

69.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

69.2.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

69.3.Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрхэд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хагас жил тутамд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

69.4.Энэ зүйлийн 69.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, 69.3-т заасан үрчлэгдсэн хүүхдийн эрхэд хяналт тавих журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

69.5.Үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлтийг шүүхэд гаргах эрхтэй.

70 дугаар зүйл.Хүүхэд үрчилснээс үүсэх үр дагавар

70.1.Үрчлэгдсэн хүүхэд төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

70.2.Хүүхдийг үрчлүүлснээр төрсөн эцэг, эх хүүхдийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг дуусгавар болно.

70.3.Хүүхдийн үрчлэгдэхээс өмнө өмчилж эзэмшиж байсан эд хөрөнгө үрчлэгдсэний дараа хэвээр хадгалагдана.

70.4.Хүүхдийг үрчлүүлсэн эцэг, эх нь үрчлэн авсан эцэг, эхээс өөрсдийг нь тэжээн тэтгэхийг шаардах, бусад эд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг шаардах эрхгүй.

70.5.Хүүхдийг үрчлүүлсэн эцэг, эх нь үрчлэн авсан эцэг, эхэд аливаа хэлбэрээр сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

70.6.Хүүхэд үрчлүүлэх үйл явц нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх бөгөөд хүүхдэд сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирол учруулахыг хориглоно.

71 дүгээр зүйл.Үрчлэлтийн нууц

71.1.Үрчлэлтийг нууцлах талаар үрчлэн авсан эцэг, эх хүсэлт гаргасан бол улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тэдгээрийн баримт бичигт нууцлалын тэмдэглэл хийнэ.

71.2.Үрчлэлтийн нууцлалыг мэдэж байгаа албан тушаалтан болон бусад этгээд нууцлалыг хадгалах үүрэгтэй.

71.3.Үрчлэлтийн нууцлалыг задруулсан этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

72 дугаар зүйл.Үрчлэлтийг хүчингүй болсонд тооцох

72.1.Сонирхогч тал үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

72.2.Үрчлэлтийг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

72.2.1.үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан;

72.2.2.тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон;

72.2.3.үрчлүүлэгч эцэг, эхийг хүүхдээ үрчлүүлэхийг удаа дараа тулган шаардаж, заналхийлж, эсхүл хууран мэхлэх замаар хүүхэд үрчилж авсан нь тогтоогдсон;

72.2.4.хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан;

72.2.5.энэ хуулийн 66.3-т заасан этгээд болох нь тогтоогдсон;

72.2.6.энэ хуулийн 65.7-д заасан үйл ажиллагаа эрхэлсэн.

72.3.Шүүх хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангаж, шаардлагатай тохиолдолд үрчлэлтийг хүчингүйд тооцох шийдвэр гаргана.

72.4.Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үрчлэлтийг хүчингүй болсонд тооцно.

73 дугаар зүйл. Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар

73.1.Үрчлэлтийг хүчингүйд тооцсон бол хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид буцаах эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

73.2.Хүүхдийг эцэг, эхэд буцаах нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлах, эсхүл хууль ёсны өөр асран хамгаалагч, харгалзан дэмжигч байхгүй бол шүүх хүүхдийг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын асран хамгаалалтад шилжүүлнэ.

73.3.Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

73.4.Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тухай шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор шүүх шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

73.5.Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага хүүхдийн овог, нэрийг үрчлэгдэхээс өмнөх овог, нэрээр бүртгэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНД ГЭР БҮЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭХ

74 дүгээр зүйл. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэрлэлт бүртгэх

74.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлтийг бүртгэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол дараах журмыг баримтална:

74.1.1.гэрлэгчдийн аль нэг нь гадаадын иргэн бол гэрлэхэд харшлах шалтгаангүй эсэхийг Монгол Улсын хуулийн дагуу тодорхойлно;

74.1.2.гэрлэгчид хоёулаа гадаадын иргэн бол тэдгээрийн гэрлэх чадамжийг тус бүрийнх нь харьяат улсын хуулиар тодорхойлно;

74.1.3.гэрлэгчдийн хэн нэг нь харьяалалгүй хүн бөгөөд Монгол Улсад гэрлэлтээ бүртгүүлэх бол гэрлэхэд харшлах шалтгаангүй эсэхийг Монгол Улсын хуулийн дагуу тодорхойлно.

74.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

75 дугаар зүйл. Дипломат төлөөлөгчийн газарт гэрлэлт бүртгэх

75.1. Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын иргэний гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гэрлэх гэрлэлтийг бүртгэнэ.

75.2. Гадаадын иргэн гэрлэлтээ Монгол Улсын нутаг дэвсгэр дэх өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлсэн бол уг гэрлэлтийг Монгол Улсад хүлээн зөвшөөрнө.

76 дугаар зүйл. Гадаад улсад бүртгүүлсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх

76.1. Монгол Улсын иргэд хоорондоо, эсхүл гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад тухайн улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэсэн нь энэ хуулийн үндсэн зарчимд харшлахгүй бол гэрлэлтийг Монгол Улсад хүчинтэйд тооцно.

76.2. Гадаад улсын иргэд хоорондоо Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна тухайн улсын хуулийн дагуу гэрлэсэн нь Монгол Улсад хүчинтэйд тооцно.

77 дугаар зүйл. Гэрлэлтийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөхгүй байх

77.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улсад бүртгэгдсэн гэрлэлтийг Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд нийцээгүй бол Монгол Улсад хүчинтэйд тооцохгүй.

78 дугаар зүйл. Гэрлэлт цуцлах

78.1. Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад бүртгэлтэй гэрлэлтийг цуцлахад Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

78.2. Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн өөрийн эхнэр, эсхүл нөхрийн харьяаллаас үл хамааран бүртгэлтэй гэрлэлтээ Монгол Улсад энэ хуульд заасан захиргааны болон шүүхийн журмаар Монгол Улсад цуцлуулж болно.

78.3. Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэлтийг захиргааны журмаар цуцалж болно.

78.4. Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гадаад улсад гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол Монгол Улсад хүчинтэйд тооцогдоно.

79 дүгээр зүйл. Гэрлэгчдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг

79.1. Гэрлэгчдийн эрх, үүргийг тэдгээрийн хамт оршин суугаа улсын хууль тогтоомж, эсхүл хэн нэг нь тухайн улсын нутаг дэвсгэрт амьдардаггүй бол хамгийн сүүлд хамт амьдарч байсан улсын хууль тогтоомж, эсхүл гэрлэлтийн гэрээнд тохиролцсоны дагуу шийдвэрлэж болно.

79.2. Хамт амьдарч байсан газар нь тодорхойгүй гэрлэгчдийн эрх, үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт энэ хууль эсхүл гэрлэлтийн гэрээний дагуу тогтооно.

79.3.Харьяалалгүй буюу хамт амьдарч байсан газар нь тодорхойгүй гэрлэгчид гэрлэлтийн болон тэтгэлэг төлөх тухай гэрээгээр аль улсын хууль тогтоомж хэрэглэхийг тохиролцож болно.

79.4.Гэрлэгчид эсхүл энэ хууль, эсхүл тэдгээрийн сонгосон улсын хуульд нийцээгүй гэрээ байгуулсан бол энэ зүйлийн 79.1-д заасныг баримтлан эрх, үүргийг тодорхойлж болно.

79.5.Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад гэрлэхдээ гэрлэлтийн гэрээ байгуулж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хувийн эрх, үүргээ тодорхойлох талаар харилцан тохиролцсон бол эрх, үүргийг гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар, сонгоогүй бол тэдгээрийн байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно.

79.6.Энэ хуулийн 76.1-д заасны дагуу гэрлэлтээ батлуулсан гэрлэгчдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргийг тэдгээрийн байнга хамт оршин суугаа улсын хуулиар тодорхойлно. Байнга хамт оршин суугаа улс байхгүй бол эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа улсын хуулиар, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргасан улсын хуулийг хэрэглэнэ.

80 дугаар зүйл.Эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг

80.1.Эцэг, эх, хүүхдийн эрх, үүргийг байнга хамт оршин суугаа улсын хууль тогтоомжийн дагуу, эсхүл талууд харилцан тохиролцсон бол Монгол Улсын хуулийн дагуу тодорхойлж болно.

80.2.Эцэг, эх нь хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй бол тэдний тэтгэлгийн болон бусад харилцаа холбоотой эрх, үүргийг хүүхдийн байнга оршин суугаа улс, эсхүл хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашгийг хангахад давуу байдал үүсгэх бол эцэг, эхийн оршин суугаа улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж болно.

81 дүгээр зүйл.Гэр бүлийн гишүүний бие биеэ тэжээн тэтгэх үүрэг

81.1.Гадаад улсад оршин суугаа насанд хүрсэн Монгол Улсын иргэн эцэг, эхээ, гэр бүлийн бусад гишүүн бие биеэ тэжээн тэтгэх үүргийг тэдгээрийн байнга хамт оршин суугаа улсын хууль тогтоомж, тэжээн тэтгэх гэрээгээр, эсхүл талууд харилцан тохиролцсон бол сонгосон улсын хуулийн дагуу тодорхойлж болно.

81.2.Байнга хамт оршин суугаа хаяггүй бол тэжээн тэтгүүлэхээр хүсэлт гаргасан этгээдийн харьяалах улсын хууль тогтоомжоор шийдвэрлэж болно.

81.3.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөж болно.

82 дугаар зүйл.Эцэг, эх тогтоох

82.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний эцэг, эх тогтоолгох асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтална.

82.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт эцэг, эх тогтоолгохтой холбоотой маргааныг Монгол Улсын хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

82.3.Гадаад улсад амьдарч байгаа хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын иргэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эцэг, эхийг захиргааны журмаар бүртгэх бол гадаад улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт хүсэлт гаргаж болно.

82.4.Гадаад улсын хуулиар Монгол Улсын иргэн хүүхдийн эцэг, эхийг тогтоосон нь энэ хуульд харшлахгүй бол хүчинтэйд тооцно.

82.5.Хүүхдийн иргэний харьяалал нь эцэг, эхийн эрх, үүрэг болон хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалахад нөлөөлөхгүй.

83 дугаар зүйл.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлэх

83.1.Хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

83.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүүхдийг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд үрчлүүлэхэд энэ хуулийн 65.2, 65.3, 65.7-д заасан үрчлэх, үрчлүүлэх зарчим, нөхцөлийг баримтална.

83.3.Монгол Улсад үрчлэн авах гэр бүл олдоогүй, эсхүл бүтэн өнчин болон эцэг, эх нь тогтоогдоогүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлнэ.

83.4.Хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргасан хүн энэ хуулийн 66.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргагдсан, тус улсад дахин оруулахгүй байх хугацаа нь дуусаагүй байгаа бол хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

83.5.Хүүхдийг үрчлүүлэхдээ гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагыг сонгож, хамтран ажиллана.

83.6.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлтийн зөвлөл ажиллана.

83.7.Үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

83.8.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш ажлын тав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон үрчлэгч талд мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

83.9.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлэх чиг үүрэг бүхий Үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална

83.10.Гадаадын харьяат гэр бүлтэй ярилцлага хийх журмыг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

83.11.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авсан гадаадын харьяат гэр бүл хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал Харьяатын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

83.12.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, гэр бүлийн эрх зүйн үндсэн зарчим, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно.

84 дүгээр зүйл.Гадаад улсад үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих

84.1.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

84.2.Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг 18-н нас хүртэл Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

84.3.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн үрчлэгч гэр бүлтэй, эсхүл энэ хуулийн 83.5-д заасан итгэмжлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулна.

84.4.Энэ зүйлийн 84.3-т заасан гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, хүүхдэд эх орныг нь таниулах, хүүхдийн нөхцөл байдалтай танилцах, түүний хэрэгжилтийн тайлан хүргүүлэх хугацааг тохиролцож байгуулна.

84.5.Үрчлэгдсэн хүүхдийн мэдээлэл, энэ зүйлийн 84.3-т заасан гэрээний хувийг харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгчийн харьяалах улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар, үрчлэлтийн асуудал хариуцсан тухайн улсын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

84.6.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэгч талд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

84.7.Үрчлэгч тал нь энэ хуулийн 72.2-т заасан нөхцөл байдлыг бий болгосон, энэ зүйлийн 84.3-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй бол үрчлэлтийг шүүх хүчингүй болгоно.

85 дугаар зүйл.Гадаадын харьяат хүүхдийг үрчилж авах

85.1.Монгол Улсын иргэн гадаадын харьяат хүүхдийг үрчилж авахад тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

АРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН

ЧИГ ҮҮРЭГ, ТОГТОЛЦОО

86 дугаар зүйл. Гэр бүлийг дэмжих, хамгаалах удирдлагын тогтолцоо

86.1. Гэр бүлийг дэмжих удирдлагын тогтолцоо нь гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгж, сум, баг, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнаас бүрдэнэ.

86.2. Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгж нь гэр бүлд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх сургалт, мэдээлэл арга зүйн төв, танхимтай байна.

86.3. Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгжийн даргыг тухайн шатны Засаг дарга, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан нэгжийн даргыг тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.

86.4. Энэ зүйлийн 86.3-т заасан албан тушаалд томилогдох албан тушаалтан Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгуурыг хангасан байхаас гадна тухайн салбарт таваас доошгүй жил ажилласан байна.

87 дугаар зүйл. Гэр бүлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх

87.1. Засгийн газар гэр бүлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

87.1.1. төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын биелэлтийг хангуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

87.1.2. гэр бүлийн харилцаанд өв, уламжлал, зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

87.1.3. улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг зорилтод гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлыг зохион байгуулах.

88 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

88.1. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

88.1.1. төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцах;

88.1.2.төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийн төслийг боловсруулж, шийдвэрлүүлэх;

88.1.3.иргэдэд гэр бүлийн албан бус боловсрол олгох үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

88.1.4.гэрлэгчдэд сургалт, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, магадлан итгэмжлэх журмыг батлах;

88.1.5.энэ хуулийн 49.2-т заасан хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг боловсруулах;

88.1.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

89 дүгээр зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

89.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

89.1.1.гэр бүлийн боловсролыг сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгад тусган хэрэгжүүлэх;

89.1.2.гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг мэргэжлийн түвшинд бэлтгэх;

89.1.3.сургууль /цэцэрлэг/-гэр бүл, багш-сурагч-эцэг, эхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

89.1.4.гэр бүлийн боловсрол олгох албан бус сургалтын хөтөлбөрийг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

89.1.5.хуульд заасан бусад чиг үүрэг.

90 дүгээр зүйл.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

90.1.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

90.1.1.гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

90.1.2.гэр бүлийн талаарх хууль тогтоомжийг сурталчлах;

90.1.3.төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд гэр бүлийн гишүүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл өгөх, арга зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх;

90.1.4.гэр бүлд зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх арга зүй, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;

90.1.5.гэр бүлийн асуудлаар салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

90.1.6.гэр бүлийн албан бус боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, гэр бүлд зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг сургах, мэргэшүүлэх;

90.1.7.гэр бүлийн үнэт зүйлийг хамгаалах, хөгжүүлэх, дэвшилтэд уламжлал, зан заншлыг өвлүүлэх, угийн бичиг хөтлөхөд дэмжлэг үзүүлэх;

90.1.8.гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах эрх бүхий байгууллага, мэргэжилтэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

90.1.9.иргэнийг асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах, хүүхэд үрчлэх болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүний нөхцөл байдалд үнэлгээ хийж, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асран хүмүүжүүлэгчтэй гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих, асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эрх ашиг хохирсон бол шүүхэд төлөөлөх;

90.1.10.хуульд заасан бусад чиг үүрэг.

91 дүгээр зүйл.Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг

91.1.Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

91.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх гэр бүлийн бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, батлах;

91.1.2.гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилт, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, Засаг даргын гэр бүлийг дэмжих үйл ажиллагаанд хяналт тавих;

91.1.3.гэр бүлийн хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, гэр бүлийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулга тавих;

91.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

92 дугаар зүйл.Бүх шатны Засаг даргын чиг үүрэг

92.1.Бүх шатны Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

92.1.1.гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

92.1.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гэр бүлийн хөгжил, хамгааллын бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр хэлэлцүүлж, тайлагнах;

92.1.3.гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

92.1.4.гэр бүлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад иргэд, олон нийтийн оролцоог хангах;

92.1.5.асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй хүнийг асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах санал, дүгнэлтэд хяналт тавих;

92.1.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

93 дугаар зүйл.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

93.1.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

93.1.1.гэр бүлийн талаарх бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;

93.1.2.гэр бүлийн гишүүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

93.1.3.энэ хуулийн 90.1.5-д заасан гэр бүлийн мэдээллийн нэгдсэн санд гэр бүлийн мэдээллийг оруулах;

93.1.4.иргэн, олон нийтэд гэр бүлийн албан бус боловсрол олгох сургалт, хүүхэд асран хамгаалах, харгалзан дэмжих, үрчлэх хүсэлтэй иргэд, гэр бүлийн гишүүдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх;

93.1.5.гэр бүлийн үнэт зүйлийг хамгаалах, хөгжүүлэх, дэвшилтэт уламжлал, зан заншлыг өвлүүлэх, угийн бичиг хөтлөхөд гэр бүлд дэмжлэг үзүүлэх;

93.1.6.иргэн, хуулийн этгээдтэй гэр бүлд чиглэсэн ажил үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

93.1.7.хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, хяналт тавих;

93.1.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

94 дүгээр зүйл.Гэр бүлийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

94.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

94.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

95 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

95.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тэтгэлэг тогтоолгосон шүүхийн шийдвэрийг тэтгэлэг авагч тал, түүний хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасантай нийцүүлэн ирээдүйд авах тэтгэлгийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай хүсэлт шүүхэд гаргана.

96 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

96.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг